



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/580

Номгон

Газар албадан чөлөөлөх үйл ажиллагаа  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 57 дугаар зүйлийн 57.3, 57.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газрыг чөлөөлөх, албадан нүүлгэх ажлыг 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2.Дээрх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, зөрчил гаргаж нийтийн эзэмшлийн газарт зөвшөөрөлгүйгээр газар эзэмшиж хашаа, барилга барьсан иргэдийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Эрх бүхий байгууллага, албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр газар эзэмшиж баригдсан хашаа, барилгыг хуулийн хүрээнд албадан буулгаж, газрыг чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээр гаргуулж газрыг хэвийн байдалд оруулж ажиллахыг Ажлын хэсэг (Д.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

4.Газар чөлөөлөх, албадан нүүлгэхэд эсэргүүцсэн, хүч хэрэглэсэн буюу зохион байгуулалттайгаар саатуулах үйлдэл гаргахаас урьдчилан сэргийлж, зохих журмын дагуу арга хэмжээ авч, хэв журам сахиулахыг Цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа (Д.Мөнгөнтулга)-д үүрэг болгосугай.

5.Албадан буулгах үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, ажлын үр дүнг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Д.Алтангэрэл)-т үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

642311455

Аймгийн Засаг даргын 1683 оны 10 дугаар  
сарын 17-ны өдрийн 1569 дугаар захирамжийн  
хавсралт

## ГАЗАР АЛБАДАН ЧӨЛӨӨЛӨХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Алтангэрэл Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Гишүүд:

Д.Мөнгөнтулга Цагдаагийн газрын нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, Цагдаагийн дэд хурандаа

Х.Цэнд-Очир Онцгой байдлын газрын Аврах, гал унтраах 16-р ангийн захирагч, ахмад

А.Цэцэнбилэг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга

Б.Намуун Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

Ц.Уянга Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Байгаль орчин, газар, Геодези зурагзүйн хяналтын улсын байцаагч

Б.Отгончимэг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн


Багийн Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга:

С.Должинсүрэн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

аймгийн Засаг даргын 2023 оны  
10 дугаар сарын 17 ны өдрийн 460 дугаар  
захирамжийн хавсралт



ГАЗРЫН ЗӨРЧИЛ ГАРГАСАН ИРГЭДИЙН  
ЖАГСААЛТ

Д/д	Газрын байршил	Иргэн, Аж ахуйн нэгж байгууллагын нэр	Зөрчлийн утга
1	Баянхонгор сум, Номгон 1-р баг, Чандмань гудамж-1, 121 дүгээр байранд байрлах "Baby story" дэлгүүр	Л.Сэргэлэнбат	Зөвшөөрөлгүй дэлгүүрийн барилгын өргөтгөл барьсан
2	Баянхонгор сум, Есөнбулаг 9-р баг, Тээвэрчдийн гудамж-4, 400а тоот хаягт байрлах "Стандарт ноос" ХХК-ний эзэмшил газрын баруун талын хэсгийн хашаа	"Стандарт ноос" ХХК	"Стандарт ноос" ХХК нь эзэмшил газрын баруун талын хэсгийн хашаагаа бусдын эзэмшил газарт оруулж барьсан

оОо